



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А-97

Улаанбаатар хот

Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 13 дугаар зүйл, 20¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-174 дүгээр тушаалаар батлагдсан “Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам”-ын 2 дахь хэсгийн 2.2-т заасан “90 хоног” гэснийг “6 сар”, “90 хоногоос” гэснийг “6 сараас” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам”-ын 2 дахь хэсгийн 2.4-т заасан “зээлийн хүүн дээр 5 (таван) нэгж хувийг нэмсэнтэй” гэснийг хассугай.

3. Энэ тушаалыг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдөж ажилсугай.

4. Энэхүү тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Тайлан бүртгэлийн газар (Ц.Гарьд), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14. 0564

Tushaal 2020.doc